



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 14 (347)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай
- Өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2004 оны дөрөвдүгээр сарын 15

№ 14 (347)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

167.	Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай	Дугаар 9	277
168.	Сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай	Дугаар 10	278
169.	Зарим хүмүүсийг сонгуулийн ерөнхий хорооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 11	278
170.	Сонгуулийн ерөнхий хорооны зарим гишүүнийг нөхөн томилох тухай	Дугаар 12	278

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

167.	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 20	278
168.	Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 35	285
169.	Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 43	286
170.	Тооны дээд хязгаар тогтоох тухай	Дугаар 44	286
171.	Орон тоо, зардлын хязгаарыг тогтоох тухай	Дугаар 45	287
172.	Төрийн өмчийн хорооны гишүүнээс чөлөөлөх, томилох тухай	Дугаар 46	287
173.	Журам батлах тухай	Дугаар 48	287
174.	Гамшгаас хамгаалах тухай Хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 51	292
175.	Дүрэм батлах тухай	Дугаар 52	295
176.	Өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай	Дугаар 53	298

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 9

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг 2004 оны 4 дүгээр сарын 12-өдрөөс товлон зарласугай.

2. Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал хураалтыг 2004 оны 6 дугаар сарын 27-ны өдөр явуулахаар тогтоосугай.

3. Энэ тогтоолын 2004 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДЭДДАРГА Ж. БЯМБАДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Сонгуулийн Ерөнхий хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

төсвөөс гаргахыг Засгийн газар /Н. Энхбаяр-т даалгасугай.

3. Энэ тогтоолыг 2004 оны 4 дүгээр сарын 12 -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1. Монгол Улсын Их Хурлын 2004 оны ээлжит сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 696578660 төгрөгөөр тогтоосугай.

2. Энэхүү зардлыг 2004 оны батлагдсан

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2. Энэ тогтоолын 2004 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1. Ч. Амарболд, Ч. Даваасүрэн, Д. Намсрай, Н. Гүмэндэмбэрэл нарыг өөр ажилд шилжсэнтэй холбогдон Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Сонгуулийн ерөнхий хорооны зарим гишүүнийг нөхөн томилох тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр нөхөн томилсугай.

2. Энэ тогтоолын 2004 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1. Гандийн Бямбацэрэн, Бэгзийн Очирбат, Данзангийн Сандаг-Очир, Чимэдийн Хүрэлбаатар нарыг Монгол Улсын Их Хурлын дэргэдэх

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.1, 12.5, 17.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

лавлагаа өгөх үйлчилгээний хураамжийн хэмжээг 2 дугаар хавсралт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний загвар (тодорхойлолт)-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалт зөтлөх журмыг 1 дүгээр хавсралт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалтаас

2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, бүртгэлийн дэвтэр хэвлүүлэх зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээ авахыг



Санхүү, эдийн засгийн сайд Ч. Улаанд даалгасгай.

20-ны өдрийн 267 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа нарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.ЭНХБАЯР

**САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД**

Ч.УЛААН

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Ц.НЯМДОРЖ

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Заслийн газрын 1991 оны 9 дүгээр сарын

Засгийн газрын 2004 оны 20 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЖАГСААЛТ ХӨТЛӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1-д заасан бүртгэх байгууллага хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалт хөтлөхөд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Хуулийн этгээд байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасан тухай болон хуулийн этгээдийг үүсгэн байгуулах баримт бичиг оруулсан өөрчлөлт бусад мэдээллийг агуулсан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалтыг улсын хэмжээний нэгдсэн бүртгэлийн дэвтэрт хөтөлнө.

Хоёр. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалт хөтлөх

2.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16, 20, 23 дугаар зүйлд заасан баримт бичиг нь улсын бүртгэлийн жагсаалт хөтлөх эх сурвалж болно.

2.2. Бүртгэх байгууллага нь энэхүү журмын 1.2-т заасан дэвтэрт бичилт хийж, хуулийн этгээдийг бүртгэнэ.

2.3. Энэхүү журмын хавсралтаар батлагдсан "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалт"-д заасан бичвэрүүдийг дор дурдсан байдлаар хөтөлнө:

-01-хуулийн этгээдийг бүртгэх тухай бүртгэх байгууллагын шийдвэрийн он, сар, өдөр, дугаар;

-02-бүртгэх байгууллагаас хуулийн этгээдэд олгосон улсын бүртгэлийн дугаар;

-03-улсын бүртгэлийн регистрийн нэгдсэн сангаас олгосон регистрийн дугаар;

-04-Үндэсний татварын ерөнхий газраас баталгаажуулсан хуулийн этгээдийн нэр;

-05-хуулийн этгээдийн төрөл "ашгийн төлөө, эсхүл ашгийн төлөө бус", хэлбэр (ашгийн төлөө бол хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компани; ашгийн төлөө бус бол холбоо, сан, хөршөө г.м.)-ийг зааж өгнө. Төрийн бус байгууллагыг "нийгэмд үйлчилдэг", "гшүүддээ үйлчилдэг" гэж тус тус тэмдэглэх;

-06-10-хуулийн этгээдийн оршин байгаа газрын хууль ёсны хаяг, утасны дугаар;

-11-15-байнгын ажиллагаатай засиргаз байхгүй бол хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн хаяг, утасны дугаар;

-16-хуулийн этгээд шинээр байгуулсан эсхүл өөрчлөн байгуулагдсаныг тэмдэглэх;

-17-23-үүсгэн байгуулагчийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг тэмдэглэх;

-24-үүсгэн байгуулсан нийт гишүүний тоо / төрийн бус байгууллагын нийтийг хамарсан хурлаас байгуулсан бол энэ тухай тэмдэглэх/;

-25-26-хуульд заасан эрх бүхий байгууллагаас гаргасан хуулийн этгээд байгуулах тухай шийдвэрийн нэр, дугаар, хуулийн этгээдийн дүрэм болон үүсгэн байгуулах гэрээ байгуулсан он, сар, өдрийг тэмдэглэх;

-27-30-Үндэсний статистикийн газраас хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг салбараар нь ангилсан кодын дугаар;

-31-32-Компанийн хэлбэрээр байгуулагдаж байгаа хуулийн этгээдийн өөрийн хөрөнгийн хэмжээг мөнгөн болон биет хэлбэрээр илэрхийлэх;

-33-37-хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтны овог, нэр, албан тушаал, иргэний үнэмлэх болон регистрийн дугаар, татвар төлөгчийн бүртгэлийн дугаар;

-38-41-Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан үйл ажиллагаа эрхэлдэг бол энэ талаархи мэдээлэл;

-42-45-өөрчлөн байгуулагдаж байгаа хуулийн этгээдийн нэгдсэн, нийлсэн, хуваасан, тусгаарласан, өөрчлөгдсөний аль нь болох, эрх залгамжлагч этгээдийн нэр, регистрийн дугаар, эрх залгамжлалын хувь хэмжээ;

-46-49-өөрчлөн байгуулагдах явцад үйл ажиллагаа нь зогсоогдсон хуулийн этгээдийн талаархи мэдээлэл;

-50-салбар, төлөөлөгчийн газрын нэр, хууль ёсны хаяг;

-51-Бүртгэх байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэн он, сар, өдрийг тэмдэглэх;

-52- улсын бүртгэлд бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг;

-53-хуулийн этгээдийн харилцах банкны нэр, дансны төрөл, дугаар. Эдгээр мэдээллийг эрх бүхий байгууллагаас баталсан маягтын дагуу хуулийн этгээдийн харилцагч банкнаас ирүүлсэн тасалбарыг үндэслэж бүртгэсэн ажилтны гарын үсэг, бүртгэсэн он, сар, өдөр;

-54-хуулийн этгээдийг үүсгэн байгуулах баримт бичигт орсон өөрчлөлт, баримт бичгийн төрөл, өөрчлөлтийн агуулга, он, сар, өдөр, түүнийг бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг;

-55-хуулийн этгээдийг хууль тогтоожийн дагуу татан буулгах эрх бүхий байгууллага болон татан буулгах комиссын шийдвэрийн он, сар, өдөр, дугаар, хуулийн этгээд татан буугдаж байгаа тухай тэмдэглэл хийсэн бүртгэх байгууллагын ажилтны нэр, гарын үсэг он, сар, өдөр, дугаар, улсын бүртгэлээс хассан он, сар, өдөр, түүнийг улсын бүртгэлд бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг.

2.4. Бүртгэх байгууллага хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дэвтэрт бичигдсэн жагсаалтыг улсын бүртгэлийн цахим санд давхар хөтөлнө.

2.5. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим сан болон регистрийн нэгдсэн сангийн тогтвортой хэвийн ажиллагааг Үндэсний татварын ерөнхий газар хариуцна.

2.6. Бүртгэх байгууллагууд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим сангийн нэгдсэн сүлжээнд холбогдоно.

2.7. Үндэсний татварын ерөнхий газар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим сан болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн регистрийн нэгдсэн санг улсын хэмжээнд хамтад нь хөтөлж, хуулийн этгээдийн нэр давхардаж байгаа эсэхийг шалган, нэрийн баталгаажуулалт хийнэ.

2.8. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалт бүхий дэвтэр, улсын бүртгэлийн гэрчилгээг Үндэсний татварын ерөнхий газраас нэгдсэн журмаар хэвлүүлж, дугаарлан бүртгэх байгууллагуудад хүргүүлнэ.

2.8.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дэвтрийг ББХХДД гэсэн дарааллаар дугаарлах бөгөөд энэ нь дараахь агуулгыг илэрхийлнэ:

-ББ-бүртгэх байгууллагын дугаар;

-ХХ-хуулийн этгээдийн төрөл, хэлбэр;

-ДД-тухайн улсын бүртгэлийн байгууллагад ашиглагдаж байгаа дэвтрийн дугаар.

2.9. Улсын бүртгэлийн жагсаалт дахь хуулиар хориглосноос бусад мэдээлэл нийтэд нээлттэй, ил тод байх бөгөөд бүртгэх байгууллага нь иргэн, хуулийн этгээдэд лавлагаа мэдээлэл өгч болно.

2.10. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн регистрийн нэгдсэн сан нь хуулийн этгээдийн тухай улсын хэмжээний мэдээлэл өгөх үндсэн эх сурвалж болно.

2.11. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим сан дахь мэдээллийг нотлох баримт бичиг нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалт бүхий дэвтэр болно. Улсын бүртгэлийн цахим сан дахь мэдээлэл, бүртгэлийн дэвтэр дэх мэдээллүүд зөрвөл бүртгэлийн дэвтэр дээрх мэдээллийг үндэслэл болгоно.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн
жагсаалт хөтлөх журмын хавсралт

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮТГЭЛИЙН ЖАГСААЛТ

Бүртгэсэн байгууллагын шийдвэрийн огноо, дугаар		01					
Улсын бүртгэлийн дугаар		02					
Регистрийн дугаар		03					
Хуулийн этгээдийн нэр		04					
Хуулийн этгээдийн төрөл, хэлбэр		05					
Хуулийн этгээдийн хууль ёсны хаяг	Аймаг, нийслэл	06					
	Сум, дүүрэг	07					
	Баг, хороо	08					
	Байршил	09					
	Утасны дугаар	10					
Байнгын ажллагаатай ерөнхий захиргаа байхгүй бол тухайн хуулийн этгээдийг итгэмжлэгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн хаяг	Аймаг, нийслэл	11					
	Сум, дүүрэг	12					
	Баг, хороо	13					
	Байршил	14					
Утасны дугаар		15					
Хуулийн этгээд байгуулсан арга /шинээр эсхүл өөрчлөн байгуулсан/		16					
Үүсгэн байгуулагчийн талаар	Овог	17					
	Эцэг (эх)-ийн нэр	18					
	Нэр	19					
	Иргэний үнэмлэх, регистрийн дугаар	20					
	Иргэний харьяалал	21					
	Өмчийн хэлбэр	22					
Хаяг, утасны дугаар		23					
Үүсгэн байгуулсан гишүүний тоо		24					
Үүсгэн байгуулах баримт бичиг	Эрх бүхий байгууллагын шийдвэрийн нэр, дугаар	25					
	Дүрэм, үүсгэн байгуулах гэрээний огноо	26					
Үйл ажиллагааны чиглэл /Код/	Үндсэн	27					
	2 дэгч	28					
	3 дэгч	29					
	4 дэгч	30					
Өөрийн хөрөнгийн хэмжээ /мян.төг/	Мөнгөн хөрөнгө	31					
	Биет	32					

	Овог	33			
	Нэр	34			
Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан	Албан тушаал	35			
	Иргэний үнэмлэх, регистрийн дугаар	36			
	Татвар төлөгчийн бүртгэлийн дугаар	37			
	Тусгай зөвшөөрлөөр эрхлэх аж ахуйн үйл ажиллагаа	38			
Эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн бүртгэл	Шийдвэр гаргасан эрх бүхий байгууллагын нэр	39			
	Шийдвэрийн огноо	40			
	Дугаар	41			
	Өөрчлөн байгуулагдсан хэлбэр /нэгдсэн, нийлсэн, хуваасан, тусгаарласан, оорчлогдсон аль нэгийг бичих/	42			
Өөрчлөн байгуулагдаж байгаа хуулийн этгээдийн талаар	Хуулийн этгээдүүдийн нэр	43			
	Регистрийн дугаар	44			
	Эрх залгамжлалын хувь	45			
	Нэр	46			
Өөрчлөн байгуулалтад хамрагдсан хуулийн этгээдийн талаар	Регистрийн дугаар	47			
	Эрх залгамжлалын хувь	48			
	Үйл ажиллагаа зогсоосон огноо	49			
	Салбар, төлөөлөгчийн газрын нэр, оршин байгаа газрын хаяг	50			
Улсын бүртгэлд бүртгэсэн огноо	51				
Улсын бүртгэлд бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг	52				

53. Харилцах банкны бүртгэл.

Д/д	Харилцах банкны нэр	Дансны дугаар		Бүртгэсэн: Огноо, Ажилтны нэр, гарын үсэг, тэмдэг
		Төгрөгийн	Валютын	
01				
02				
03				
04				
05				
06				
07				
08				
09				

54. Үүсгэн байгуулах баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл:

Л/д	Баримт бичгийн төрөл	Өөрчлөлтийн агуулга	Огноо	Бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг, тэмдэг

55. Татан буулгаж байгаа тухай бичилт болон улсын бүртгэлээс хассан бүртгэл:

Татан буулгах вийдвэр гаргасан	Вийдвэр гаргасан эрх бүхий байгууллагын нэр	
	Вийдвэрийн огноо	
	Вийдвэрийн дугаар	
Татан буугдаж байгаа тухай тэмдэглэл хийсэн бүртгэлийн ажилтны нэр, гарын үсэг, огноо, тэмдэг		
Татан буулгах комиссын вийдвэр, огноо, дугаар		
Улсын бүртгэлээс хассан огноо		
Улсын бүртгэлд бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг		

Д/д	Аймаг, нийслэл	Тооны дээд хязгаар
1	Архангай	110
2	Баян-Өлгий	80
3	Баянхонгор	207
4	Булган	30
5	Говь-Алтай	52
6	Говьсүмбэр	10
7	Дархан-Уул	44
8	Дорноговь	32
9	Дорнод	60
10	Дундговь	60
11	Завхан	150
12	Орхон	15
13	Өвөрхангай	50
14	Өмнөговь	50
15	Төв	60
16	Увс	10
17	Сүхбаатар	104
18	Сэлэнгэ	50
19	Ховд	50
20	Хөвсгөл	79
21	Хэнтий	90
22	Улаанбаатар	85
	Бүгд	1478

Засгийн газрын 2004 оны 20 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЖАГСААЛТААС ЛАВЛАГАА ӨГӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

1. Бүртгэх байгууллага нь хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр улсын бүртгэлийн жагсаалтаас энэ журмын 1.3-т заасан үйлчилгээний хураамж авч лавлагаа өгнө.

2. Бүртгэх байгууллага яаралтай лавлагааг ажлын 8 цагт багтаан өгөх бөгөөд энэ журмын 1.3-т заасан үйлчилгээний хураамжийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж авна.

3. Бүртгэх байгууллага нь хуулийн этгээдийн талаар лавлагаа өгөхдөө дор дурдсан хэмжээний хураамж авна:

3.1. Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан эсэхийг шалгаж, баталгаажуулалт хийх-500 төгрөг;

Энэ заалт нь хуулийн этгээдийг анх бүртгүүлэхэд хамаарахгүй.

3.2. Улсын бүртгэлийн жагсаалтаас лавлагаа өгөх (Улсын бүртгэлийн жагсаалтын үзүүлэлт тус бүрээс)-200 төгрөг;

3.3. Холбогдох баримт бичгийн хуулбар өгөх(хуудас тутамд)-400 төгрөг.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ нь 297х210 мм-ийн хэмжээтэй, 200 гр/м-ын жинтэй, 80%2-иас дээш цайралт бүхий, бал, бэхээр болон компьютер хэрэглэж бичихэд тохиромжтой сайн чанарын цаасан дээр хэвлэгдсэн байна.

2. Улсын бүртгэлийн гэрчилгээ нь дэвсгэр хээний цогцолбор, хүрээ хээ, нүдэнд үл үзэгдэх хэвлэлт, үндсэн бичвэр зэргээс бүрдэх бөгөөд эдгээр нь чанарын өндөр түвшинд үнэт цаасны хэвлэлийн нууцлалтайгаар хэвлэгдсэн байна.

3. Гэрчилгээний нийт гадаргууг дүүргэж байрлах дэвсгэр хээ нь гэрчилгээний нүүрэн талд хоёр захаасаа төв рүүгээ цайвар ногооноос цайвар хул шаргалруу ууссан өнгөөр хэвлэгдсэн байх ба суурь хээ, бичил бичвэр, соёмбоны суурь хээ, алхан хээ, бичвэр хээ, соёмбо зэргээс, гэрчилгээний ар талд суурь хээ, алхан хээ зэргээс тус тус бүрдсэн цогцолбор хээ юм.

3.1. Суурь хээг түмэн наст хээ болон алхан хээг хослуулсан хамар хээг 0,09 хэмжээтэй нарийн зураасааар товойлгон урласан байх бөгөөд тодорхой хэсгүүдэд тогтмол бус хэмнэлтэйгээр нууцлалын түвшинд хэвлэгдсэн байна.

3.2. Гэрчилгээний гарчиг бичвэрийг дэвсэж 0,6 пунктын хэмжээтэй "Монгол Улс, Улсын Бүртгэлийн Гэрчилгээ" гэсэн 37 мөр бүхий долгионтсон бичил бичвэр байрлана.

3.3. Гэрчилгээний зүүн дээд хэсэгт байрлах алтан соёмбыг суурилож нарийн зураасуудаар нууцлалын тодорхой хэмнэлтэйгээр хэвлэгдэх соёмбоны суурь хээ байрлана.

3.4. Дэвсгэр хээний доод хэсэгт үндэсний алхан хээг тодорхой хэмнэл, өнцгүүдээр зурагдсан нарийн зураасуудаар дүүргэж хэвлэсэн байна.

3.5. Дэвсгэр хээний төв хэсэгт тодорхой хэмнэлүүд бүхий өөр хоорондоо харилцан адилгүй өнцгүүдээр зурагдсан зургаан талт нарийн зураасаар хэвлэгдсэн соёмбо байрлана.

3.6. Соёмбоны дээд талд тодорхой хэмнэлүүд бүхий нарийн зураасаар дүүргэгдэж

хэвлэгдэх "Монгол Улс", соёмбоны доод талд "Улсын Бүртгэлийн Гэрчилгээ" гэсэн бичвэр хээнүүд тус тус байрлана.

3.7. Гэрчилгээний ар талд, нүүрэн талд байрлах суурь хээ болон алхан хээг тэдгээрээс хэмнэлийн зөрүүтэйгээр хэвлэсэн байна.

4. Дэвсгэр хээ болон гэрчилгээний үндсэн бичвэрүүдийг хашиж хүрээ хээ байрлах бөгөөд улаан туяа бүхий хар ногоон өнгөөр хэвлэгдсэн байна. Хүрээ хээ нь тодорхой хэмнэл бүхий угалзсан нарийн зураасан хээ, бичил бичвэр, булангийн хээ, алхан хээ зэргээс бүрдэнэ.

5. Гэрчилгээний нүүрэн талын төв хэсэгт соёмбо болон гэрчилгээний ар талын доод хэсэгт "Улсын Бүртгэлийн Гэрчилгээ" гэсэн бичвэрүүдийг тус тус нүдэнд үл үзэгдэх будгаар хэвлэсэн байх ба эдгээрийг зөвхөн тусгай зориулалтын гэрлээр харахад зориулагдсан байна.

6. Гэрчилгээний нүүр болон ар талд батлагдсан загварын дагуу үндсэн бичвэрүүд байрлана:

6.1. Гэрчилгээний зүүн дээд буланд алтан соёмбоны дээр "УБ-2", баруун дээд буланд "Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 20 дугаар тогтоолоор батлав" гэсэн бичилтүүд байрлана.

6.2. Гэрчилгээний дээд хэсэгт "Монгол Улс, Улсын Бүртгэлийн Гэрчилгээ" гэсэн гарчиг бичилтийг гэрчилгээний хүрээ хээний өнгөөр хэвлэсэн байна.

6.3. Гэрчилгээний үндсэн бичвэрүүд дээрээсээ дараахь дарааллаар байрлана. Үүнд:

-1-2 дахь мөр: Зүүн дээд буланд бүртгэсэн "Он, сар, өдөр", баруун дээд буланд "Улсын бүртгэлийн дугаар", "Регистрийн дугаар" /2мөрөнд багтана/.

-3-5 дахь мөр: "Хуулийн этгээдийн нэр, хэлбэр", "Үүсгэн байгуулах баримт бичиг", үүсгэн байгуулсан "Шийдвэр", "Дугаар", "Огноо" (4 мөрөнд багтана).



-6 дахь мөр: "Код", "Үйл ажиллагааны чиглэл" (3 мөрөнд багтана).

-7 дахь мөр: "Хугацаа", "Гишүүдийн тоо", "Өөрийн хөрөнгийн хэмжээ (мян.төг)".

-8 дахь мөр: "Хуулийн этгээдийн хууль ёсны хаяг" (2 мөрөнд багтана).

-9 дэх мөр: "Бүртгэсэн байгууллагын нэр" (2 мөрөнд багтана). 9 дэх мөрийн зүүн доод талд тамга дарах зайд "Тамга" гэсэн бичилт голлож байрлана.

Гэрчилгээний арын хэсэгт харилцагч банкны бүртгэл, хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл, "Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй," гэсэн бичвэрүүд байрлана.

7.Улсын бүртгэлийн гэрчилгээ нь загвар, хэвлэлтийн хувьд үнэт цаасны хэвлэлтийн нууцлалын дээд түвшинд хамрагдана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулах тогтолцоог 2004 онд шинэчлэн байгуулахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга П.Даш нарт даалгасгай.

5. Баригдсан барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварыг үнэлж паспортуулах ажлыг 2004-2005 онд багтаан дуусгаж газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн шаардлага хангаагүй орон сууц болон бусад барилгын талаар авах арга хэмжээний тухай санал боловсруулж Засгийн газарг танилцуулахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасгай.

6. Газар хөдлөлтийн үед биеэ хамгаалах болон газар хөдлөлтийн хор уршгийн талаар сургалт сурталчилгааг радио, телевизээр 2004 оноос эхлэн явуулж байхыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга Б.Ганболд, Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга П.Даш нарт үүрэг болгосгай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Газар хөдлөлтөөс учрах хохирлыг багасгах, урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1998 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 206 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	Н.ЭНХБАЯР
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД	Ч.УЛААН
ДЭД БҮТЦИЙН САЙД	Б.ЖИГЖИД

1. Болзошгүй хүчтэй газар хөдлөлтийг судлах, инженер-сейсмологийн судалгаанд шаардлагатай нүүдлийн станц авахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Шинжлэх ухааны академийн саналыг үндэслэн хандивлагч орнуудын зээл, тусламжийн хүрээнд болон улсын төсөвт тусгах замаар шийдвэрлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид нарт даалгасгай.

2. Инженер-сейсмологийн иж бүрэн судалгаа хийж, газар хөдлөлтийн бичил мужлалын зураг зохиох арга хэмжээнд жил бүр хоёроос доошгүй хот, суурин газрыг хамруулж, шаардагдах хөрөнгийг шинжлэх ухаан, технологийн сан болон улсын төсвөөс санхүүжүүлж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасгай.

3. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газрын Газар хөдлөлт, техникийн магадлалын албанд барилга байгууламжийн хийц, бүтээцийн чанар байдлыг тогтооход хэрэглэх төхөөрөмж худалдан авахад шаардагдах 45.0 (дөчин таван) сая төгрөгийг улсын төсвийн хуваарилагдаагүй зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрч тус албаны үйл ажиллагааны 2004 оны урсгал зардалд шаардагдах 45.8 (дөчин таван сая найман зуун мянган) сая төгрөгийг төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж цаашид уг зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд үүрэг болгосгай.

4. Монгол Улсад ашиглагдаж байгаа мэдээлэл, холбооны техник хэрэгсэлд тулгуурлан

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Төрийн албаны тухай хуулийн 28.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн жишгийг дор дурдсанаар шинэчлэн тогтоож 2004 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй:

Дүүргийн Засаг дарга
88200-104000
Сумын Засаг дарга
82000-97600
Хорооны Засаг дарга
66400-78900
Багийн Засаг дарга
57700-69500

2. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргын албан тушаалын

Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай цалинг тухайн шатны Засаг даргын албан тушаалын цалинтай адил байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 196 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН
САЙД **Ш.БАТБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2004 онд цэргийн алблыг дүйцүүлэн хаах иргэдийн тооны дээд хязгаарыг хавсралт ёсоор баталсугай.

Тооны дээд хязгаар тогтоох тухай
2. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу хаалгах арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД **Ж.ГҮРРАГЧАА**

Засгийн газрын 2004 оны 44 дүгээр тогтоолын хавсралт

2004 онд цэргийн дүйцүүлэх албанд элсүүлэх иргэдийн тооны дээд хязгаар

№/д	Аймаг, нийслэл	Тооны дээд хязгаар
1	Архангай	110
2	Баян-Өлгий	60
3	Баянхонгор	207
4	Булган	30
5	Говь-Алтай	52
6	Говьсүмбэр	10
7	Дархан-Уул	44
8	Дорноговь	32
9	Дорнод	60
10	Дундговь	60
11	Завхан	150
12	Орхон	15
13	Өвөрхангай	50
14	Өмнөговь	50
15	Төв	40
16	Увс	10
17	Сүхбаатар	104
18	Сэлэнгэ	50
19	Довд	50
20	Ховсгөл	79
21	Хэнтий	90
22	Улаанбаатар	85
	Бүгд	1478

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Чөлөөт бүсийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 болон 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны орон тоог 16-гаас, зардлыг 49900.0 (дөчин есөн сая есөн зуун мянга) мянган төгрөгөөс, чөлөөт бүсэд ажиллах мэргэжлийн хяналтын албаны орон тоог 15-аас дээшгүй байхаар тогтоосугай.

2. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсэд ажиллах гааль, татвар, хил хамгаалах байгууллагын бүтэц, орон тоо болон хэв журам

Орон тоо, зардлын хязгаарыг тогтоох тухай

сахиулах, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албуудыг ажиллуулах зэрэг асуудлыг тухайн үед нь зохих журмын дагуу шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Чөлөөт бүсийн захирагчид үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
САЙД

Ч.ГАНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Санхүү, эдийн засгийн дэд сайдаар ажиллаж байсан Л.Энхтайваныг Төрийн өмчийн хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.

2. Төрийн өмчийн хорооны гишүүнээр Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн

Орон тоо, зардлын хязгаарыг тогтоох тухай

бичгийн дарга Ч.Хүрэлбаатарыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн ажиллах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Засгийн газрын 2003 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 117 дугаар тогтоолоор баталсан "Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дүрэм"-д дор дурдсан өөрчлөлт оруулсугай:

а/ 1 дүгээр заалт, 9 дүгээр заалтын 3, 14 дүгээр заалтын 2, 3-т "үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн" гэснийг, 7 дугаар заалтын "үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн бүртгэл" гэснийг 9

Журам батлах тухай

дүгээр заалтын "үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэлийн" гэснийг тус тус "эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн" гэж өөрчилсүгэй;

б/ 9 дүгээр заалтын 2, 4, 6, 9, 10, 12-ыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2/ төрөөс хувьчилсан газар, орон сууц болон бусад эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн нотлох баримтыг үндэслэн эрхийн улсын бүртгэлд бүртгэх;

4/ шүүхийн шийдвэрийн үндсэн дээр эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигч, ашиглагч өөрчлөгдсөнийг бүртгэх, эд хөрөнгийг захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлэх, сэргээх;

6/ эд хөрөнгө өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгох журмыг батлах, эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг нэглэсн үндсэн дээр эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгох, гэрчилгээний зарцуулалтын тайлан гаргах;

9/ эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн хувийн хэрэг нээх, бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлэх, архив, мэдээллийн сангийн үйл ажиллагааг стандартын дагуу эрхлэн явуулах, хэдгэлалт, хамгаалалтын шаардлагыг хангаж ажиллах;

10/ эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаархи улсын нэгдсэн мэдээг сар, улирал, жилээр гаргах;

12/ улсын бүртгэгч болон эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэгтэй харьцах эрх бүхий

албан тушаалтнаар нууцын баталгаа гаргуулан ажиллуулах.

в/ 9 дүгээр заалтын 1, 8-ын "үл хөдлөх", 14 дүгээр заалтын 7-гийн "болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээний" гэснийг тус тус хассугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм, журам шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2001 оны 1 дүгээр сарын 24-ний едрийн 11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.ЭНХБАЯР

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ө.ЭНХТҮВШИН

*Засгийн газрын 2004 оны 48 дугаар
тогтоолын хавсралт*

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Эд хөрөнгийн эрхийн улсын ерөнхий бүртгэгч, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч (цаашид "ерөнхий бүртгэгч", "улсын бүртгэгч" гэх) нь эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийг эрхийн улсын бүртгэл (цаашид "эрхийн улсын бүртгэл" гэх)-д бүртгэж баталгаажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2. Ерөнхий бүртгэгч, улсын бүртгэгч нь үйл ажиллагаандаа Иргэний хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж болон энэхүү журмыг удирдлага болгоно.

3. Ерөнхий бүртгэгч, улсын бүртгэгч нь үйл ажиллагаандаа хуулийг дээдлэх, төрийн албан хаагчийн ёс зүйг чандлан сахиж, шийдвэр гаргахдаа бусдын нөлөөнд үл автаж, шударга байх, чирэгдэлгүй, соёлтой үйлчлэх зарчмыг баримтална.

4. Ерөнхий бүртгэгч, улсын бүртгэгч нь Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 12.2-т заасан шаардлагыг хангасан байна.

5. Ерөнхий бүртгэгч нь "эрхийн улсын ерөнхий бүртгэгч" гэсэн бичвэр, хувийн дугаар бүхий тэмдэгтэй байж, ерөнхий бүртгэгчийн албан бичгийн болон захирамжлалын хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

6. Улсын бүртгэгч нь эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх эрхийн улсын бүртгэгчийн хувийн дугаар бүхий тэмдэгтэй байна.

Хоёр. Ерөнхий бүртгэгч, улсын бүртгэгчийн эрхлэх үйл ажиллагаа

7. Ерөнхий бүртгэгч дараахь үйл ажиллагааг эрхэлнэ:

1/эрхийн улсын бүртгэлийн албыг мэргэжлийн удирдлагаар хангаж, өдөр тутмын үйл ажиллагааг нь зохион байгуулж, хяналт тавих;

2/Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.5, 18.3, 37.2-т заасан холбогдох заавар, журам, маягтыг баталж мөрдүүлэх;

3/эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн архив, мэдээллийн санг бүрдүүлж,

архив, мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын найдвартай болон байдлыг хангах асуудлыг зохион байгуулж, тэдгээрийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих;

4/эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

5/эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ (цаашид "гэрчилгээ" гэх)-ний бичилт, зарцуулалт, олголтод хяналт тавих;

6/шүүхийн шийдвэрээр хүчингүй болгосон болон үзэгдүүлсэн, гээгдүүлсэн гэрчилгээг хүчингүй болгож, нөхөн олгох талаар холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэр гаргах;

7/Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.3, 7.5, 7.6, 12.6, 18.6 болон 20 дугаар зүйл, 23.1-д заасны дагуу улсын бүртгэгч бүртгэлийг алдаатай хийсэн эсэхийг тогтоож, алдаатай бол бүртгэлд өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хаах шийдвэр гаргах;

8/тухайн эд хөрөнгийн анхны өмчлөгч болон барьцаалсан, түрээслэсэн, худалдаж, арилжсан, хамтран өмчлөгч нэмэгдсэн, хасагдсан, өв залгамжлал, гэрээслэл мөн шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдсөн, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгдсэн талаархи нотлох баримт, нотолгоо, тайлбар, лавлагааг эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийн архивын нотлох баримтад үндэслэн бүх шатны шүүх, цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх зэрэг хуулийн байгууллагад гарган өгч, эд хөрөнгийн эрхийн талаархи маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримтуудаар ханган, хуульд заасны дагуу криминалистик шинжилгээний эх материал, хувийн хэргийг бэлтгэж өгөх;

9/шаардлагатай тохиолдолд эд хөрөнгийн маргаан болон эрхийн улсын бүртгэлтэй холбоотой шүүх хуралд орох;

10/эрхийн улсын бүртгэлийн талаархи улсын нэгдсэн дүн мэдээг гаргаж, холбогдох газрууд, олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах;

11/эрхийн улсын бүртгэлийн асуудлаар болон улсын бүртгэгчийн үйл ажиллагаатай холбоотой гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч, хянан шийдвэрлэх.

8. Улсын бүртгэгч дараахь үйл ажиллагааг эрхэлнэ:

1/иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөх эрх үүсэх тухай нотлох баримтуудыг эрх зүйн үүднээс хянан дүгнэлт өгч, өмчлөх эрхийг төрөөс баталгаажуулан, тухайн эд хөрөнгийн хувийн хэрэг, архивыг үүсгэн бий болгож;

2/эд хөрөнгө өмчлөх эрхийг баталгаажуулахтай холбогдсон өмчлөгч өөрчлөгдөх, хамтран өмчлөгч нэмэгдэх, хасагдах, гэрээслэл, өв залгамжлал зэрэг тухайн өмчтэй холбоотой эрхийн улсын бүртгэлийг өмчийн талаархи архивын нотлох баримт бүхий хувийн хэрэгт бүртгэх бүртгэл явуулах;

3/эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж баталгаажуулсан эд хөрөнгө худалдах, бэлэглэх, арилжих, түрээслэх, барьцаалж зээл авах зэрэг үйлдлүүдийн эрхийн улсын бүртгэлийг тухайн эд хөрөнгийн архивын хувийн хэрэгт нь бүртгэж байгуулагдсан гэрээг хуулийн дагуу хүчин төгөлдөр болгох;

4/эрхийн улсын бүртгэлийн мэдүүлэг (цаашид "мэдүүлэг" гэх)-ийг хүлээн авч, эрх зүйн дүгнэлт өгөн, мэдүүлэг болон түүнд хавсаргасан нотлох баримтын хуудас бүрт хүлээн авсан тэмдэг дарж, хуудсыг дугаарлан, хүлээж авсан огноо, цаг, минутыг бичсэний дараа цахим санд мэдээллийг оруулна. Цахим мэдээллийн сан байхгүй нөхцөлд эрхийн улсын бүртгэлийн холбогдох дэвтрүүдийг хөтөлнө;

5/эрхийн улсын бүртгэлийн талаархи аливаа бүртгэлийг хийхдээ ямар үйлчилгээг хийлгэх гэж байгаа тухай өмчлөгчийн тодорхойлолтыг нотлох баримтын бүрдэлд заавал авах;

6/эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг (цаашид "хувийн хэрэг" гэх)-ийг нээн хөтөлж, эрхийн улсын бүртгэлийн код, дугаар олгон, гэрчилгээнд бичилт хийж, нотлох баримтыг мэдүүлэг орж ирсэн огнооны дарааллаар дугаарлаж, хуудасны дугаарыг баруун дээд өнцөгт нь бичиж үдэх;

7/эд хөрөнгө өмчлөх, эзэмших, барьцаалах, ашиглах эрхтэй холбоотой гэрээ хэлцэл, өөрчлөлт, хөдөлгөөнийг бүртгэж, хувийн хэрэгт баяжилт хийх бөгөөд гэрээ хэлцэлд "эрхийн улсын бүртгэлд бүртгэв" тэмдгийг дарж, мэдүүлэг гаргасан огноог тавин, гарын үсгээ зурж, гэрээг хуулийн дагуу хүчин төгөлдөр болгох;

8/анхны бүртгэлийг хийхдээ өмчлөгчийн өөрийнх нь гаргасан өргөдөлд эд хөрөнгийн байршил, хэмжээ, зориулалт зэргийг тодорхой тусгуулахаас гадна хамтран өмчлөгч бий эсэх, хэрэв байгаа бол хамтран өмчлөгчдийн овог, нэр, регистрийн дугаарыг, хамтран өмчлөгч байхгүй бол байхгүй гэдгийг нь өөрөөр нь нотлон бичүүлж, нотариатаар гарын үсгэний үнэн зөвийг, мөн бүх өмчлөгчдийн иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбарыг гэрчлүүлснээр авах, мөн Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 17.1.6-д заасныг баримтлан ажиллах;

9/иргэн, хуулийн этгээдийн өөрийнх нь хөрөнгөөр баригдсан нийтийн орон сууцны барилгыг бүртгэхдээ өмчлөгчдийн нэрсийн жагсаалт, сууцны үнийг төлсөн тодорхойлолт, барилгыг улсын комисст хүлээлгэн өгсөн тухай акт, фото зураг, план зураг зэргийг үндэслэн бүртгэх, энэ үндсэн дээр тухайн орон сууцны барилгаас худалдагдсан байр, өрөөг мэдүүлгээр орж ирсэн гэрээний үндсэн дээр дараагийн өмчлөгчид шилжүүлэн бүртгэж, эхний өмчлөгчийн гэрчилгээнээс хасалт хийх замаар бүртгэх;

10/газар өмчлөх эрхийг баталгаажуулж, эрхийн улсын бүртгэлд бүртгэхдээ газрын нэгж, талбарын дугаар олгогдсон эсэхийг хянах;

11/нотлох баримтад эд хөрөнгийн 4 талаас нь бүрэн харуулсан фото зургийг заавал хавсаргах, 4 талаас нь авах боломжгүй тохиолдолд объектыг алсаас бүтэн харуулсан фото зургийг авч, уг фото зурган дээр тухайн объектыг улаанаар тойруулан зурж, тодотгож өгөх, хэрэв нийтийн орон сууц бол орон сууцны барилгын фото зургийг бүхэлд нь авч тухайн байрныг нь цонхыг дугуйлан тэмдэглүүлэх, фото зургийг А4 хэмжээтэй цаасан дээр наалгаж, объектын аль тал нь болохыг өмчлөгчөөр нь бичүүлэн хүлээж авах;

12/нотлох баримтад эд хөрөнгийн план зургийг заавал хавсаргах бөгөөд план зурагт эд хөрөнгийн талбайг өмчлөгчөөр нь тодорхойлуулж, бичүүлсэн байх;

13/эд хөрөнгө өмчлөх эрх нь нэг этгээдээс нөгөөд шилжсэн тохиолдолд эхний өмчлөгчийн гэрчилгээг хүчингүй болгох бөгөөд гэрчилгээнд "хүчингүй" гэсэн тэмдэг дарж огноо тавин, хувийн хэрэгт хавсаргах;

14/эд хөрөнгийн өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл хийх бүрт шинэ өмчлөгчдийн иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээний хуулбарыг нотариатаар гэрчлүүлснээр хавсаргаж байх;

15/Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу мэдүүлэг гаргагчийн шаардлагын хэмжээнд лавлагаа, хуулбар гаргаж өгөх бөгөөд лавлагааны хуудсанд хувийн дугаар бүхий тэмдэг дарж, гарын үсгээ зурж баталгаажуулаа;

16/эрхийн улсын бүртгэлтэй холбогдож ирүүлсэн болон явуулсан албан бичиг, өргөдөл, өргөдлийн хариу, шүүхийн шийдвэр, шүүхэд гаргасан тайлбар, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн актууд, эрхийн улсын ерөнхий бүртгэгчийн шийдвэр зэрэг холбогдох нотлох баримтуудыг тухайн хувийн хэрэгт хавсарган, холбогдох бичилтийг хувийн хэрэгт бүрэн гүйцэд хийж байх;

17/эрхийн улсын бүртгэлийн мэдээллийг боловсруулан цахим санд оруулах;

18/архиваас хувийн хэргийг хүлээн авч, тухайн ажлын өдөрт багтаан архивт буцаан хүлээлгэж өгч хувийн хэргийг хүлээлцсэн гарын үсэг зурах;

19/мэдүүлэг гаргагчийн мэдүүлгийг буцаахдаа бүртгэхээс татгалзсан үндэслэл, тайлбарыг тодорхой бичиж, гарын үсгээ зуран, хувийн дугаар бүхий тэмдгээ дарж, буцаасан огноог тавих;

20/эрхийн улсын бүртгэлд бүртгэж баталгаажуулсан гэрээ, хэлцэл, гэрчилгээ, лавлагаа, бүртгэхээс татгалзсан мэдүүлгийг түүнд хавсаргасан баримт бичгийн хамт мэдүүлэг

гаргагчийн биеийн байцаалтыг нь үндэслэн олгож, хүлээн авсан этгээдээр гарын үсэг зуруулах, хэрэв итгэмжлэлээр үйлчлүүлэх бол итгэмжлэлийн нотариатаар гэрчлэгдсэн хувийг авах;

21/эрхийн улсын бүртгэлийн мэдээ болон гэрчилгээний зарцуулалтын тайланг сар бүр гаргаж, дараа сарын 5-ны дотор өгөх;

22/өөрийн гүйцэтгэсэн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой шүүх хуралдаанд оролцох;

23/аливаа эрхийн улсын бүртгэлийн талаархи хувийн хэргийн бичилт, лавлагаа, гэрчилгээнд хувийн дугаар бүхий тэмдгийг тэгш, тод, гаргацтай, бүтэн дарах;

24/эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэгт холбогдох бичилтүүдийг тухай бүр нь хар бэхээр дэлгэрэнгүй гаргацтай бичиж, түүнтэй холбогдох нотлох баримтын хуудасны дугаарыг зааж, бичилт хийсэн огноо, эрхийн улсын бүртгэгчийн хувийн дугаар бүхий тэмдэг дарж, гарын үсэг зурж баталгаажуулах.

Гурав. Ерөнхий болон улсын бүртгэгчийн эрх, үүрэг

9. Ерөнхий бүртгэгч нь Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаас гадна дараахь эрхийг эдэлнэ:

1/улсын бүртгэгчид үүрэг даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавих;

2/архиваас хувийн хэргийг татан үзэж, шалгах, хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авах;

3/улсын бүртгэгчийн үйл ажиллагааг шалгах, дүгнэх болон холбогдох бусад арга хэмжээг авч ажиллах.

10. Ерөнхий бүртгэгч нь дараахь үүрэг хүлээнэ:

1/нотлох баримт хуурамчаар бүрдүүлсэн болон эрх бүхий этгээд албан тушаалаа ашиглаж хууль бус шийдвэр, тодорхойлолт гаргасан нь эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад илэрвэл энэ тухай холбогдох хуулийн байгууллагад мэдэгдэх;

2/өөрийн гаргасан шийдвэр болон эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргаар хянуулах;

3/хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

11. Улсын бүртгэгч нь дараахь эрх эдэлнэ:

1/нотлох баримт бичиг дутуу гэж үзвэл мэдүүлэг гаргагчаас нэмэлт материал шаардах;

2/эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг нотлох баримт бичгийн талаар эргэлзээ төрвөл ерөнхий бүртгэгчээс туслалцаа дэмжлэг авах, холбогдох нотлох баримтыг хянуулж, дүгнэлт гаргуулах;

3/удирдлагын зүгээс нотлох баримт дутуу, хууль бус бүртгэл хийхийг үүрэг болгох, шаардах тохиолдолд түүнээс татгалзах;

4/биеийн байцаалт, эсхүл итгэмжлэлгүй хүнд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн талаар үйлчлэхгүй байх;

5/хууль тогтоомжид заасан бусад эрх.

12. Улсын бүртгэгч нь дараахь үүрэг хүлээнэ:

1/мэдүүлэг гаргагч мэдүүлгийг үнэн зөв, гүйцэд бөглөсөн эсэхийг шалгах;

2/нотлох баримтын бүрдэл гүйцэд, үнэн зөв эсэхэд дүгнэлт өгч, эрхийн улсын бүртгэлийг үнэн зөв гүйцэтгэх;

3/тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлсийг зохих журмын дагуу бүрэн гүйцэд төлүүлэх;

4/мэдүүлэгт хавсаргасан баримт бичгийг хүлээн авсан огнооны дарааллаар дугаарлаж, хувийн хэргийг эмх цэгцтэй байлган, нягт нямбай хөтлөх;

5/зөвхөн өөрийн хариуцах хувийн хэргийг архиваас авах;

6/өөрийн буруутай үйлдлээс гэрчилгээ буруу бичигдэж хүчингүй болбол түүний үнийг зохих журмын дагуу төлөх;

7/өөрийн хариуцан бүртгэсэн бүртгэлийн хувийн хэргийн нотлох баримтын бүрдэл болон бүртгэлийн үнэн зөвийг хуулийн өмнө хариуцах;

8/эрхийн улсын бүртгэлтэй холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн нууцыг хадгалах;

9/хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

13. Эрхийн улсын бүртгэгчийн үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглоно:

1/хүлээж авсан мэдүүлэг, түүнд хавсрагдах нотлох баримтыг дарагдуулах, алга болгох, хууль зүйн үндэслэлгүйгээр буцаах;

2/анхны бүртгэлийг хийхдээ зөвхөн анхны өмчлөгчийг бүртгэсний дараа дараагийн өмчлөгчид шилжүүлсэн бүртгэл хийх, өөрөөр хэлбэл анхны өмчлөгчөөс хэд хэдэн өмчлөгчид дамжсан байхад хамгийн сүүлийн өмчлөгчөөр анхны бүртгэл хийх;

3/үйлчлүүлэгчдийг чирэгдүүлэх, хүнд суртал гаргах, тэдэнд хууль бус шаардлага тавих, зүй бусаар харилцах;

4/өөрийн гүйцэтгэх бүртгэлийн үйл ажиллагаанд хамааралгүй хувийн хэргийг архиваас авч үзэх;

5/үүрэгт ажлаа гүйцэтгэсний төлөө шан харамж авах;

6/хувийн хэрэгт засвар хийх, хүлээж авсан мэдүүлгээс гадуур нотлох баримт нэмэх, хасах, нотлох баримтыг устгах, хувийн хэргийг алга болгох, хувийн хэргийн хуудсыг устгаж үгүй болгох;

7/нотлох баримтыг хуурамчаар үйлдэхэд оролцох, энэ талаар заавар зөвлөгөө өгөх; лавлагаа, мэдээллийг нотлох баримтаас зөрүүтэйгээр хуурамчаар гаргаж өгөх, хувийн дугаар бүхий тэмдгээ ашиглах боломжийг бусдад олгох, хувийн дугаар бүхий тэмдгээ хууль бусаар ашиглах;

9/улсын бүртгэгчийн хувийн дугаар бүхий бусдын тэмдгийг ашиглах;

10/эрхийн улсын бүртгэлийн дугаарыг давхардуулан олгох, тухайлбал нэг эд хөрөнгөд нэгээс илүү дугаар олгох, эсхүл өөр өөр эд хөрөнгөд нэг дугаар олгон хувийн хэрэг нээж бүртгэл хийх, дугаарыг алгасаж олгох;

11/эрхийн улсын бүртгэлд өмнө нь бүртгэгдсэн эд хөрөнгийг хууль бусаар дахин бүртгэж, гэрчилгээ олгох;

12/эрхийн улсын бүртгэлд хөдөлгөөн хийх эрхийг түдгэлзүүлсэн тухай ерөнхий бүртгэгч, эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга болон эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллагын шийдвэрийг зөрчиж, бүртгэлд хөдөлгөөн хийх.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 27 - ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 15.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гамшгаас хамгаалах ерөнхий газрын харьяа салбар, нэгжийг хавсралт ёсоор баталсугай.

2. Гамшгаас хамгаалах ерөнхий газрын харьяа салбар, нэгжийн зохион байгуулалт, орон тоог батлагдсан төсөвтөө багтаан тогтоож мөрдөхийг Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга П.Дашид үүрэг болгосугай.

3. Аймаг, нийслэл, дүүргийн Гамшгаас хамгаалах штабыг тухайн Засаг даргын эрхлэх

асуудлын хүрээнд агентлаг хэлбэрээр ажиллуулахаар тогтоосугай.

4. Татан буугдсан Гал түймэртэй тэмцэх газар, Иргэний хамгаалалтын газар, Улсын нөөцийн газрын төсвийг тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцаас Ерөнхий сайдын төсвийн багцад шилжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

5. "Аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий бүтэц, орон тоо, удирдлагын бүдүүвчийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйл болон "Нийслэлийн Засаг

даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтоолын 6 дугаар зүйлд "Цэрэг-иргэний хамгаалалтын штаб" гэснийг тус тус "Цэргийн штаб" гэж өөрчилсүгэй.

6. Цэрэг-иргэний хамгаалалтын штабыг Цэргийн штаб болгосонтой холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн Цэрэг-иргэний хамгаалалтын штабын иргэний хамгаалалтын чиг үүрэг бүхий орон тоог зохих төсөв, зардлын хамт Гамшгаас хамгаалах штабт шилжүүлэхийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын дор дурдсан тогтоол, тогтоолын заалтыг хүчингүй болсонд тооцсугай:

а/Галын аюулаас хамгаалах газрын талаар авах зарим арга хэмжээний тухай" 1991 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 90 дүгээр тогтоол;

б/Иргэний хамгаалалтын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 1994 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 185 дугаар тогтоол;

в/Улсын нөөцийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 1997 оны 12 дугаар сарын

3-ны өдрийн 232 дугаар тогтоолын 6 дугаар зүйлээс бусад зүйл, заалт;

г/Зарим отряд, салбарыг өргөтгөх, байгуулах, санхүүжүүлэх тухай" 1996 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 169 дүгээр тогтоол;

д/Аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий бүтэц, орон тоо, дирдлагын бүдүүвчийг шинэчлэн тогтоох тухай" 2000 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн "Гал түймэртэй тэмцэх алба" гэсэн хэсэг;

е/Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоох тухай" 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн "х" заалтыг.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **Н.ЭНХЕАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**
Ө.ЭНХТҮВШИН

*Засгийн газрын 2004 оны 51 дүгээр
тогтоолын хавсралт*

ГАМШГААС ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА САЛБАР, НЭГЖ

1. Архангай аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 51 дүгээр анги, аврах отрядтай/.

2. Баянхонгор аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 16 дугаар ангитай/.

3. Булган аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 20 дугаар анги, аврах салбар, Хангал сумын Хялганат хороон дахь гал унтраах Ш зэрэглэлийн 55 дугаар ангитай/.

4. Баян-Өлгий аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах Ш зэрэглэлийн 31 дүгээр ангитай/.

5. Говь-Алтай аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 59 дүгээр ангитай/.

6. Говьсүмбэр аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах Ш зэрэглэлийн 37 дугаар ангитай/.

7. Дорнод аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах I зэрэглэлийн 52 дугаар анги, аврах отрядтай/.

8. Дархан-Уул аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах I зэрэглэлийн 22 дугаар анги, гал унтраах П зэрэглэлийн 54 дүгээр анги, Шарын гол суман дахь гал унтраах Ш зэрэглэлийн 50 дугаар ангитай/.

9. Дорноговь аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 33 дугаар ангитай/.

10. Дундговь аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах Ш зэрэглэлийн 25 дугаар ангитай/.

11. Завхан аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 43 дугаар анги, Тосонцэнгэл суман дахь гал унтраах Ш зэрэглэлийн 39 дүгээр ангитай/.

12. Орхон аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах I зэрэглэлийн 56 дугаар ангитай/.

13. Өмнөговь аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах Ш зэрэглэлийн 21 дүгээр ангитай/.

14. Өвөрхангай аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 12 дугаар анги, Хархорин суман дахь гал унтраах Ш зэрэглэлийн 45 дугаар ангитай/.

15. Сүхбаатар аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах Ш зэрэглэлийн 15 дугаар ангитай/.

16. Сэлэнгэ аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах I зэрэглэлийн 36 дугаар анги, аврах салбар, Хөтөл суман дахь гал унтраах Ш зэрэглэлийн 61 дүгээр анги, Мандал суман дахь гал унтраах Ш зэрэглэлийн 19 дүгээр ангитай/.

17. Төв аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 24 дүгээр анги, аврах салбартай/.

18. Увс аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах Ш зэрэглэлийн 41 дүгээр ангитай/.

19. Ховд аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах Ш зэрэглэлийн 48 дугаар анги, аврах отрядтай/.

20. Хөвсгөл аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 27 дугаар анги, аврах салбартай/.

21. Хэнтий аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 32 дугаар анги, аврах салбартай/.

22. Нийслэл дэх Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах I зэрэглэлийн 10 дугаар анги, аврах отрядтай, дүүргийн Гамшгаас хамгаалах штабууд, гал унтраах П зэрэглэлийн 14 дүгээр анги, 18 дугаар анги, 26 дугаар анги, 28 дугаар анги, 30 дугаар анги, 34 дүгээр анги, 63 дугаар анги, 64 дүгээр анги, гал унтраах Ш зэрэглэлийн 11 дүгээр анги, 65 дугаар анги, 80 дугаар ангигудтай/.

23. Гамшгаас хамгаалах тусгай анги /шуурхай бүлэгтэй/.

24. Хангалт үйлчилгээний анги /тээврийн хэсэгтэй/.

Хоёр. Аж ахуйн тооцоотой

25. Улаанбаатар хот дахь хүнсний нөөцийн салбар.

26. Улаанбаатар хот дахь "объект №3" (бараа, өвс тэжээлийн нөөцийн салбартай).

27. Орхон аймаг дахь бараа, өвс тэжээлийн нөөцийн салбар.

28. Дорнод аймаг дахь бараа, өвс тэжээл, шатахуун, үр тарианы нөөцийн салбар.

29. Увс аймгийн Баруунтуруун сум дахь өвс тэжээл, үр тарианы нөөцийн салбар.

30. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум дахь өвс тэжээл, үр тарианы нөөцийн салбар.

31. Баян-Өлгий аймаг дахь өвс тэжээл, шатахууны нөөцийн салбар.

32. Завхан аймаг дахь өвс тэжээл, шатахууны нөөцийн салбар.

33. Дорноговь аймаг дахь өвс тэжээл, шатахууны нөөцийн салбар.

34. Дундговь аймаг дахь өвс тэжээл, шатахууны нөөцийн салбар.

35. Ховд аймаг дахь бараа, өвс тэжээл, шатахууны нөөцийн салбар.

36. Архангай аймгийн Түвшрүүлэх сум дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

37. Баянхонгор аймаг дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

38. Булган аймаг дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

39. Говь-Алтай аймаг дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

40. Говьсүмбэр аймаг дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

41. Өмнөговь аймаг дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

42. Өвөрхангай аймгийн Сант сум дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

43. Сүхбаатар аймгийн Түмэнцогт сум дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

44. Төв аймгийн Бүрэн сум дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

45. Увс аймаг дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

46. Хөвсгөл аймаг дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

47. Булган аймгийн Сэлэнгэ сум дахь үр тарианы нөөцийн салбар.

48. Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь үр тарианы нөөцийн салбар.

49. Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум дахь үр тарианы нөөцийн салбар.

50. Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь үр тарианы нөөцийн салбар.

51. Төв аймгийн Цээл сум дахь үр тарианы нөөцийн салбар.

52. Төв аймгийн Жаргалант сум дахь үр тарианы нөөцийн салбар.

53. Хөвсгөл аймгийн Тариалан сум дахь үр тарианы нөөцийн салбар.

54. Дархан-Уул аймаг дахь өвс тэжээл, шатахуун, үр тарианы нөөцийн салбар.

55. Сэлэнгэ аймгийн Баянгол сум дахь шатахууны нөөцийн салбар.

56. Улаанбаатар хот дахь шатахууны нөөцийн салбар.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 27- ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 31.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.ЭНХБЯАР

"Гамшгаас хамгаалах байгууллагын албан хаагчийн сахилгын дүрэм"-ийг хэвсралт ёсоор

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ө.ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2004 оны 52 дугаар тогтоолын хэвсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИЙН САХИЛГЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

б/төр, засгийн бодлогыг

1. Гамшгаас хамгаалах байгууллагын албан хаагчдад тавигдах нийтлэг шаардлага, түүнийг биелүүлэхэд амжилт гаргагчдыг шагнах, урамшуулах, шаардлагыг зөрчигчдөд сахилгын шийтгэл ногдуулахад энэ дүрмийг дагаж мөрдөнө.

хэрэгжүүлэх;

в/удирдлагаас шийдвэр гаргахад нөлөөлөхгүй байх.

2. Гамшгаас хамгаалах байгууллагын албан хаагч /цаашид "албан хаагч" гэх/-ийн эрх зүйн болон ёс зүйн хэмжээг Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга тогтооно.

5. Албан хаагч дор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

а/албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараах;

3. Албан хаагч нь өргөсөн тангарагтаа үнэнч байж, дор дурдсан хууль тогтоомж, холбогдох төрийн захиргааны байгууллагын болон албан тушаалтны шийдвэрийн заалтыг ёсчлон биелүүлнэ:

б/төр, засгийн бодлого, шийдвэрийг гуйвуулан шүүмжлэх;

в/аль нэг улс төрийн хүчин, намыг илт дэмжих буюу шүүмжлэх байдлаар ялгавартай хандах;

а/Төрийн албаны тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж;

г/төрийн үйлчилгээг үзүүлэхдээ иргэд болон байгууллага, аж ахуйн нэгжийг өмчийн хэлбэрээр ялгаварлах, танил тал харах, хүнд суртал гаргах, чирэгдүүлэх;

б/энэ дүрэм, Засгийн газрын шийдвэр, Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын тушаал;

д/тухайн байгууллагын өмч хөрөнгө, техник хэрэгсэл, мэдээ, мэдээллийн санг албаны бус зорилгоор ашиглах;

в/Гамшгаас хамгаалах ерөнхий газар, аймаг, нийслэлийн Гамшгаас хамгаалах штаб, харьяалагдах салбар, нэгжийн зохих шатны удирдлагын шийдвэр;

е/өөрийн албан тушаалын давуутай тал, боломжийг хувийн зорилгоор ашиглах;

г/аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын шийдвэр.

ж/албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, бүдүүлэг зан авир гаргах.

4. Албан хаагч дараахь үүргийг сахиж мөрдөнө:

6. Албан тушаалын зэрэглэл, цолны эрэмбээр адил албан хаагчид хамтарч үүрэг гүйцэтгэх үед захирах даргаас тэдний хэн нь ахлахыг заавал тогтоож өгнө.

а/үүргээ шударгаар биелүүлэх;

Хоёр. Шагнал, урамшуулал

7. Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлд зааснаас гадна албан хаагчдыг дор дурдсанаар шагнаж урамшуулна:

а/баяр хүргэж бие бүрэлдэхүүнд мэдээлэх;

б/бурьд оногдуулсан сахилгын шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах;

в/зүригийг нь хүндэт самбарт тавьж алдаршуулах;

г/байгууллагын хүндэт дэвтэрт нэрийг нь бичих;

д/батлагдсан журамд нийцүүлэн хугацааны өмнө цол олгох.

8. Албан хаагч нь энэ дүрмийн 3, 4-т заасан хэм хэмжээ, үүргээ биелүүлэх талаар онцгой болон тогтвортой амжилт гаргасан нь шагнаж урамшуулах үндэслэл болно.

9. Албан хаагчдад шагнал, урамшуулал олгоходоо түүний гаргасан амжилт, ажилласан хугацаа, албаны төрөл, мэргэжлийг харгалзана.

10. Албан хаагчдад дор дурдсан удирдах албан тушаалтан дараахь шагнал урамшууллыг олгоно:

а/энэ дүрмийн 7 дахь заалтын "а"-д зааснаар харьяалагдах ажилтандаа баяр хүргэх урамшууллыг бүх шатны дарга;

б/Төрийн албаны тухай хуулийн 31.1.1, 31.1.2, 31.2-т заасан шагнал, энэ дүрмийн 7 дахь заалтын "б", "в", "г" -д заасан урамшууллыг Гамшгаас хамгаалах штабын болон Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга;

в/энэ дүрмийн 7 дахь заалтын "д"-д заасан шагналыг Гамшгаас хамгаалах штабын болон Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга;

г/Төрийн албаны тухай хуулийн 31.1.3-т заасан шагналд Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга тодорхойлно.

11. Албан хаагчийг шагнаж, урамшуулах саналыг дор дурдсанаар уламжилна:

а/салбар, нэгжийн дарга нь энэ дүрмийн 7 дахь заалтын "б"-д зааснаар харьяалах ажилтнаа урамшуулах саналыг харьяа салбар, нэгжийн шийдвэр гаргах эрх бүхий даргад, тэр нь

Гамшгаас хамгаалах штабын даргад, штаб нь Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргад;

б/харьяа салбар, нэгжийн шийдвэр гаргах эрх бүхий дарга нь Төрийн албаны тухай хуулийн 31.1.1, 31.1.2-т болон энэ дүрмийн 7 дахь заалтын "в", "г"-д зааснаар шагнаж урамшуулах саналыг Гамшгаас хамгаалах штабын даргад, штаб нь Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргад;

в/газрын тэргүүн дэд, дэд дарга, газар, хэлтсийн дарга нь энэ дүрмийн 7 дахь заалтын "б", "в", "г", "д"-д болон Төрийн албаны тухай хуулийн 31.1.1, 31.1.2-т зааснаар шагнаж, урамшуулах тухай саналыг Гамшгаас хамгаалах штабын болон Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргад.

12. Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга Төрийн албаны тухай хуулийн 31.1.1, 31.1.2, 31.2-т болон энэ дүрэмд заасан бүх шагнал урамшууллыг олгох эрхтэй бөгөөд 31.1.3-т зааснаар Засгийн газар, төрийн дээд байгууллагад тодорхойлно.

13. Шагнал, урамшууллыг бие бүрэлдэхүүн, хамт олны өмнө, эсхүл хурал цуглаан дээр амаар буюу тушаал уншин мэдэгдэж, хүндэтгэлийн байдалтай олгох буюу мэдээлнэ.

Гурав. Сахилгын шийтгэл

14. Энэ дүрэм, дотоод албаны дүрэм, дотоод журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь эрүүгийн болон захиргааны харууцлага хүлээлгэхээргүй бол албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулна.

15. Албан хаагч энэ дүрмийн 3, 4-т заасан хэм хэмжээ, үүргээ зөрчсөн, эсхүл хангалтгүй биелүүлсэн нь сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

16. Сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлийг заавал шалгаж тогтоон, энэ тухай баримт, үндэслэлийг зөрчил гаргасан албан хаагчид урьдчилан танилцуулсан байна. Зөрчил гаргасан албан хаагч уг баримт материалтай танилцаад нэмэлт тайлбар хийх, дахин шалгахыг шаардах эрхтэй.

17. Албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулахдаа Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 1995 оны 97 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, энэ талаар төрийн дээд шатны байгууллагад гомдол гаргах журам"-ыг мөрдөнө.

18. Албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 26.1-д зааснаас гадна дор дурдсан шийтгэл ногдуулна:

а/төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг 3 сар хүртэл хуагцаагаар хасах;

б/цолны цалинг 3 сар хүртэл хуагцаагаар хасах;

в/цолыг нэг шатаар бууруулах, эсхүл цол олгохыг хойшлуулах;

19. Албан хаагчид ногдуулах сахилгын шийтгэл нь зөрчлийн шинж, учруулсан хохирол, гэм бурууд тохирсон байна.

20. Сахилгын шийтгэлийг дор дурдсан албан тушаалтан ногдуулна:

а/Төрийн албаны тухай хуулийн 26.1.1-д заасан сахилгын шийтгэлийг бүх шатны дарга;

б/энэ дүрмийн 18 дахь заалтын "а", "б"-д заасан сахилгын шийтгэлийг тухайн албан хаагчийг ажилд томилсон дарга;

в/Төрийн албаны тухай хуулийн 26.1.1-26.1.3-т болон энэ дүрэмд заасан сахилгын шийтгэлийг Гамшгаас хамгаалах штабын болон Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга.

21. Албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах саналыг дор дурдсанаар уламжилна:

а/тухайн албан хаагчийг харьяалах дарга нь Төрийн албаны тухай хуулийн 26.1.2-т болон энэ дүрмийн 18 дахь заалтын "б"-д заасан шийтгэл ногдуулах тухай саналыг салбар, нэгжийн даргад, салбар, нэгжийн дарга нь тухайн албан хаагчийг ажилд томилсон даргад;

б/салбар, нэгжийн дарга нь Төрийн албаны тухай хуулийн 26.1.3-т, энэ дүрмийн 18 дахь заалтын "в"-д заасан шийтгэл ногдуулах тухай саналаа Гамшгаас хамгаалах штабын болон Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргад.

22. Дүрэм, журмаар тогтоосон хэм хэмжээг анх удаа зөрчсөн албан хаагчид гэм бурууг тайлбарлан ойлгуулсны үндсэн дээр амаар сануулж болно.

23. Гаргасан зөрчил нь жижүүрлэлтийн үед болон бүлэглэн үйлдэгдсэн, эсхүл согтуурсан, өмч хөрөнгө шамшигдуулсан бол шийтгэлийг хүндрүүлэх үндэслэл болно.

24. Гамшгаас хамгаалах штабын болон ерөнхий газрын даргын тушаалаар албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулж, өөрт нь мэдэгдэн бие бүрэлдэхүүнд танилцуулна.

25. Дүрэм, журмаар тогтоосон хэм хэмжээг сахиулах талаар арга хэмжээ аваагүй, зөрчил дутагдлыг нуун дарагдуулсан албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэхээсрүүг бол энэ дүрэмд заасан сахилгын шийтгэл ногдуулна.

26. Сахилгын шийтгэлийг давхардуулан болон албан хаагчийн нэр хүндийг гутаах, дарамтлах зорилгоор ногдуулахыг хориглоно.

27. Сахилгын шийтгэл арилгах эрхийг үг шийтгэлийг ногдуулсан дарга эдэлнэ. Шаардлагатай гэж үзвэл дээд шатны дарга шийтгэлийг арилгаж болно.

28. Сахилгын шийтгэлийг илрүүлснээс болон гаргаснаас хойшхи, түүнчлэн сахилгын шийтгэлгүйд тооцох хугацааг Төрийн албаны тухай хуулийн 26.4, 26.6-д заасныг баримтална.

29. Гамшгаас хамгаалах байгууллагын албан хаагчийн гаргасан зөрчилд захиргааны шийтгэл ногдуулсан бол сахилгын шийтгэл давхардуулан ногдуулахгүй.

30. Гамшгаас хамгаалах байгууллагын албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 1 сарын дотор төрийн дээд шатны байгууллага, эсхүл шүүхэд гаргаж болно.

Дөрөв. Бусад зүйл

31. Салбар, нэгж бүрт албан хаагчийн шагнал, урамшуулал болон сахилгын шийтгэлийн бүртгэлийг энэхүү журмын хавсралтын дагуу хөтөлнө. Бүртгэлийг жилд нэг удаа тухайн албан хаагчид танилцуулж гарын үсэг зуруулж байна.

32. Шагнал, урамшуулал, сахилгын шийтгэлийг зөв хэрэглэж байгаа эсэх болон бүртгэлийн хөтөлөлтийн байдалтай Гамшгаас хамгаалах штабын болон ерөнхий газрын дарга жилд 1 удаа танилцаж илэрсэн зөрчлийг арилгуулж байна.

33. Албан хаагч өөр салбар, нэгжид шилжсэн тохиолдолд түүний шагнал, урамшуулал болон сахилгын шийтгэлийн бүртгэлийг тухайн томилогдсон салбар, нэгжид шилжүүлнэ.



Гамшгаас хамгаалах байгууллагын албан хаагчийн сахилгын дүрмийн хавсралт

АЛБА ХААХ БҮРТГЭЛ

(Нүүр тал)

АЛБА ХААХ БҮРТГЭЛ

1. Албан тушаал
2. Цол
3. Овог, нэр
4. Албанд ирсэн ... он ... сар ... өдөр

САЙШААЛ

Юуны учир, ямар сайшаал хүртсэн	Сайшаагдсан огноо	Хэн сайшаасан	Баталгаажуулсан хүний цол, гарын үсэг	Албан хаагчийн гарын үсэг

(Ар тал)

САХИЛГЫН ШИЙТГЭЛ

Хэзээ, ямар зөрчил гаргасан	Шийтгэгдсэн он, сар, өдөр тушаалын дугаар	Хэн шийтгэсэн	Баталгаажуулсан хүний цол, гарын үсэг	Албан хаагчийн гарын үсэг

Танилцсан тухай тэмдэглэл

.....
.....
.....

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 3-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

Өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 9.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Аймаг, нийслэлийн саналыг үндэслэн 2004 онд иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ,

байршил, зориулалтыг хавсралт ёсоор тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА **Ө.ЭНХТҮВШИН**

Засгийн газрын 2004 оны 53 дугаар тогтоолын хавсралт

ИРГЭДЭД 2004 ОНД ӨМЧЛүүлэх ГАЗРЫН НИЙТ ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ

Д/д	Аймаг, нийслэлийн нэрс	Өмчлүүлэх газрын байршил	Иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ /га-гаар/	Өмчлүүлэх газрын зориулалт /га-гаар/							Үүнээс		
				Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар	Үүнээс			Аж ахуйн зориулалтаар	Үр тарваны	Төмс хүнсний ногооны	Г газр гармалынйгаас бусад аж ахуйн		
					Одоо зөвшөөж ашиглаж байгаа газрын нийт хэмжээ	Шилээр өмчлүүлэх газрын нийт хэмжээ	Шилээр өмчлүүлэх газрын нийт хэмжээ						
1	2	3	4	5	6	7	8	9	10	11			
1	Архангай	Авдгийн болон сумын төвд	18145.21	7388.91	325.5	7063.41	10756.3	8070.9	2685.4				
2	Баян-Өлгий	Авдгийн болон сумын төвд	2185	1570.4	410.6	1159.8	614.6		316	298.6			
3	Баянхонгор	Авдгийн болон сумын төвд	300.5	200.5	143.5	57	100		35	65			
4	Булган	Авдгийн болон сумын төвд	64273.1	2310.46	1056.58	1253.88	61962.64	60005	1409.5	548.14			
5	Говь-Алтай	Авдгийн болон сумын төвд	722.61	426.43	382.63	43.8	296.18	186	105	5.18			
6	Говь-сүмбэр	Авдгийн болон сумын төвд	507.04	496	50.6	445.4	11.04		6	5.04			
7	Дархан-Уул	Авдгийн болон сумын төвд	2434.7	671.5	621.1	50.4	1763.2	1672	70	21.2			
8	Дорноговь	Авдгийн болон сумын төвд	758.4	694.5	288.9	405.6	63.9		42	21.9			
9	Дорнод	Авдгийн болон сумын төвд	5547	2808	1750.6	1057.4	2739	2605.5	113.5	20			
10	Дундговь	Авдгийн болон сумын төвд	2322	2322	2195	127	0		46	2.5			
11	Завхан	Авдгийн болон сумын төвд	454.79	406.29	380.69	25.6	48.5		46	2.5			
12	Орхон	Авдгийн болон сумын төвд	961.6	757.8	388.3	369.5	203.8	150	30	23.8			

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
13	Сверлангай	Алмгийн болон сумын төвд	25.7	25.7		25.7	0			
14	Огнооговь	Алмгийн болон сумын төвд	1842.73	1585.35	304.85	1280.5	257.38		236.88	20.5
15	Сурбаатар	Алмгийн болон сумын төвд	910	910	910		0			
16	Сүхэнгэ	Алмгийн болон сумын төвд	71043.42	4756.64	2908.13	1848.51	66286.78	63507	2637.7	142.08
17	Төв	Алмгийн болон сумын төвд	248732.9	2886.88	620.22	2066.66	245846.02	242973	2851	222.02
18	Увс	Алмгийн болон сумын төвд	3798.29	1052.69	966.29	126.4	2705.6	2642.1	58.9	4.6
19	Ховд	Алмгийн болон сумын төвд	1114.2	188.2	188.2		926		922	4
20	Хөвсгөл	Алмгийн болон сумын төвд	9777.1	41	29	12	9736.1	9452	187.5	96.6
21	Хэнтий	Алмгийн болон сумын төвд	21914.16	2543.16	984.68	1558.48	19371	18400	858	113
22	Нийслэл	Нийслэлд	5153.7	5153.7	28.7	5125	0			
Улсын хэмээгд			462924.15	39236.11	15134.07	24102.04	423688.04	409663.5	12410.38	1614.16

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Хэвлэлийн хуудас 3

☎ 320487